



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 26 өдөр

Дугаар A/45

Баянбулаг

Бүх нийтийн их цэвэрлэгээ
зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5, 9.5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын төвөөс Алтан тэвшийн голын хэрсний хаяа, Баруун шанд, Баянбулаг, Баруун хар, Сүүл толгойн орчмын газруудад 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулсугай.

2.Цэвэрлэгээ хийх талбайн хуваарийг хавсралтаар баталсугай.

3.Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах ажилд төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгж, нийт иргэдийг татан оролцуулахыг байгууллагын дарга, захидал, эрхлэгч, багуудын Засаг дарга, Спортын холбоодын тэргүүн нарт үүрэг болгосугай.

4.Бүх нийтийг хамарсан зохион байгуулалттай арга хэмжээнд хариуцлагагүй хандсан албан тушаалтанд арга хэмжээ авах, гарсан санал, хийсэн ажлын тайланг 05 дугаар сарын 06-ны өдөр Засаг даргад танилцуулахыг 5 дугаар багийн Засаг дарга, Байгаль хамгаалагч нарт хариуцуулсугай.

5.Нийтийн цэвэрлэгээтэй холбогдож гарах зардлын санхүүжилтийг Засаг даргын нөөц болон бусад зардлаас гаргахыг төсөвт албан байгууллагын Нягтлан бодогч нар зөвшөөрсүгэй.

6.Зохион байгуулж буй ажилд хяналт тавин ажиллахыг Засаг даргын орлогчид даалгасугай.



642201015

2022 on zahiramj



Баянцагаан сумын Засаг даргын
оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн
A/45 дугаар захирамжийн хавсралт

**БҮХ НИЙТИЙН ИХ ЦЭВЭРЛЭГЭЭ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ТАЛБАЙН ХУВААРЬ**

№	Байгууллага, аж ахуйн нэгжийн нэр	Цэвэрлэх талбай
1	2	3
1	Соёлын төв, Цаг уурын өртөө, Баялаг бүтээгчид	Цагаан эрэгнээс - Харын үзүүр хүртэл (Ханан, Ембүү хорооллоос Баруун хар)
2	Ахмадын хороо	Цэцэрлэгт хүрээлэн
3	Эрүүл мэндийн төв	Эрээн дэрснээс – Хаалга хүртэл (эрээн дэрсний замнаас дээш)
4	Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчид, сурагчид	Баруун шанд , Голын эхнээс – Харын үзүүр, Хаалга, Тахианы байр, Модтой улаан, хогийн цэг орчим
5	Засаг даргын Тамгын газар	Алтан тэвшийн голын эхний Хэрсний хаяа, Цахирын үзүүр
6	Шагайн холбоо, Бөхийн холбоо, Уяачдын холбоо	Сүүл толгойгоос – Харын үзүүр хүртэл (суварганы замнаас баруун тийш өндөр хүчдэлийн шугам)
7	Цэцэрлэг	Харын үзүүрээс – Эрээн дэрс хүртэл (эрээн дэрсний замнаас доош Суварганы замнаас дээш)

-----оо-----